



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/25/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Буян-Ундрах Утас: 70357955 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Төлбөрийн акт	12
4.2 Албан шаардлага	12
4.4 Зөвлөмж.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ДАНС	Үзүүлэлт	Үлдэгдэл	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,263,771,819.42	1,294,149,209.97
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,497,033.00	7,447,033.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	14,497,033.00	7,447,033.00
3121	Төгрөг	14,497,033.00	7,447,033.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	14,497,033.00	7,447,033.00
33	АВЛАГА	772,397.00	32,772,397.00
335	Бусад авлага	772,397.00	32,772,397.00
3351	Байгууллагаас авах авлага	772,397.00	32,772,397.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,248,502,389.42	1,253,929,779.97
351	Түүхий эд материал	798,816,594.52	1,145,065,483.52
35110	Тусгай зориулалттай материал	796,988,576.32	1,143,310,675.32
35130	Эм боох материал	1,828,018.20	1,754,808.20
354	Хангамжийн материал	133,710,258.55	108,864,296.45
35410	Бичиг хэргийн материал	2,308,940.55	5,963,175.25
35420	Аж ахуйн материал	31,572,575.00	31,452,575.00
35430	Сэлбэг хэрэгсэл	15,286,000.00	21,144,200.00
35440	Түлш, шатах тослох материал	6,500,000.00	2,317,600.00
35460	Хүнсний материал	00.00	28,947,946.20
35470	Бусад хангамжийн материал	78,042,743.00	19,038,800.00
35300	Нормын хувцас	315,975,536.35	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,172,027,889.56	9,644,292,746.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,172,027,889.56	9,644,292,746.18
392	Биет хөрөнгө	5,786,342,689.56	8,258,607,546.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,220,492,912.83	2,242,773,318.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	-120,999,041.59	-177,826,498.87
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,463,280,709.33	7,468,274,576.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	-872,709,132.44	-1,330,355,102.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	494,709,049.72	486,940,538.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	-437,811,775.33	-458,596,408.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,519,597.52	31,741,680.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,992,685.27	-29,772,946.38
39214	Бусад үндсэн хөрөнгө	327,415,606.80	314,696,306.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-292,562,552.01	-289,267,918.61
393	Биет бус хөрөнгө	1,385,685,200.00	1,385,685,200.00
39301	Програм хангамж	900,000.00	900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-900,000.00	-900,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,385,685,200.00	1,385,685,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,435,799,708.98	10,938,441,956.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,435,799,708.98	10,938,441,956.15
51	Засгийн газрын хувь оролцоо	8,435,799,708.98	10,938,441,956.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,246,725,655.74	2,246,725,655.74
51101	Өмч: - төрийн	2,246,725,655.74	2,246,725,655.74
512	Хуримтлагдсан үр дүн	4,277,382,054.57	6,780,381,473.58
51210	Өмнөх үеийн үр дүн	4,277,382,054.57	4,277,739,226.41
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,502,642,247.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,911,691,998.67	1,911,334,826.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,435,799,708.98	10,938,441,956.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,584,852,407.00	9,412,745,459.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	226,204,504.00	342,684,293.00
120	Нийтлэг татварын бус орлого	106,937,504.00	332,304,293.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	104,270,504.00	327,454,293.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	104,270,504.00	327,454,293.00
120009	Бусад орлого	2,667,000.00	4,850,000.00
122	Тусламжийн орлого	119,267,000.00	10,380,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	119,267,000.00	10,380,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,358,647,903.00	9,070,061,166.99
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,962,415,300.00	3,193,978,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,962,415,300.00	3,193,978,500.00

**Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,721,337,483.00	3,046,808,393.99
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	167,325,500.00	8,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,217,429,859.00	2,422,650,441.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	234,033,848.00	78,230,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	102,548,276.00	537,427,952.99
1330	Төсвийн захирагчдаас	1,674,895,120.00	2,829,274,273.00
133003	Хөрөнгийн	1,674,895,120.00	2,829,274,273.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,006,121,701.38	6,910,103,212.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,006,121,701.38	6,910,103,212.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,753,082,423.31	6,766,764,072.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,430,933,426.00	2,551,779,869.00
210101	Үндсэн цалин	1,543,742,626.00	1,465,090,669.00
210102	Нэмэгдэл	836,442,300.00	1,033,280,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,748,500.00	53,408,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,205,459.00	63,393,566.00
210201	Тэтгэврийн даатгал	14,117,600.00	8,794,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,551,500.00	1,034,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,066,600.00	827,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	290,900.00	206,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,178,859.00	52,529,566.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,272,951.93	68,227,542.06
210301	Гэрэл, цахилгаан	14,339,058.82	12,769,946.50
210302	Түлш, халаалт	48,318,596.11	51,589,135.56
210303	Цэвэр, бохир ус	4,615,297.00	3,868,460.00
2104	Хангамж, бараа материалын зардал	209,523,103.00	154,643,881.30
210401	Бичиг хэрэг	7,992,860.00	3,676,763.30
210402	Тээвэр, шатахуун	200,149,043.00	148,989,470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,381,200.00	1,394,648.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	583,000.00
2105	Нормативт зардал	183,142,838.00	562,178,546.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,068,960.00	6,037,059.00
210502	Хоол, хүнс	181,408,878.00	81,644,030.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	665,000.00	474,497,456.35
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	142,134,702.00	131,656,174.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,889,731.00	5,460,882.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	67,661,440.00	88,277,892.00
210604	Урсгал засвар	46,583,531.00	37,917,400.00
2107	Томиллолт, зочны зардал	22,110,848.00	22,882,500.00
210702	Дотоод албан томиллолт	22,110,848.00	22,882,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,757,725.00	14,395,556.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	4,508,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	735,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,710,700.00	1,710,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,136,275.00	906,956.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	385,000.00	506,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,065,750.00	3,038,400.00
210807	Газрын төлбөр	3,725,000.00	3,725,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,627,001,370.38	3,197,606,438.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,289,622,841.00	2,612,257,022.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	723,460.00	01.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	336,655,069.38	585,349,416.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	253,039,278.07	143,339,139.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	210,915,800.00	11,228,330.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,116,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	167,799,800.00	11,228,330.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,123,478.07	31,005,444.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,123,478.07	31,005,444.94
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	101,105,364.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	101,105,364.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,578,730,705.62	2,502,642,247.17
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,458,333.33	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,458,333.33	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,577,272,372.29	2,502,642,247.17

**Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,246,725,655.74	1,911,691,998.67	2,700,109,682.28	6,858,527,336.69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,246,725,655.74	1,911,691,998.67	2,700,109,682.28	6,858,527,336.69
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,577,272,372.29	1,577,272,372.29
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,246,725,655.74	1,911,691,998.67	4,277,382,054.57	8,435,799,708.98
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,246,725,655.74	1,911,691,998.67	4,277,382,054.57	8,435,799,708.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	357,171.84	357,171.84
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,246,725,655.74	1,911,691,998.67	4,277,739,226.41	8,436,156,880.82
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-357,171.84	00.00	-357,171.84
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,502,642,247.17	2,502,642,247.17
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,246,725,655.74	1,911,334,826.83	6,780,381,473.58	10,938,441,956.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,686,419,783.00	6,245,636,893.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,667,000.00	4,850,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,667,000.00	4,850,000.00
120009	Бусад орлого	2,667,000.00	4,850,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,683,752,783.00	6,240,786,893.99
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,962,415,300.00	3,193,978,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,962,415,300.00	3,193,978,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,721,337,483.00	3,046,808,393.99
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	167,325,500.00	8,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчийн хуваарилсан хөрөнгө	1,217,429,859.00	2,422,650,441.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	234,033,848.00	78,230,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	102,548,276.00	537,427,952.99
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,628,976,750.00	6,024,346,893.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,628,976,750.00	6,024,346,893.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,375,937,471.93	5,881,007,754.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,430,933,426.00	2,551,779,869.00
210101	Үндсэн цалин	1,543,742,626.00	1,465,090,669.00
210102	Нэмэгдэл	836,442,300.00	1,033,280,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,748,500.00	53,408,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,205,459.00	63,393,566.00
210201	Тэтгэврийн даатгал	14,117,600.00	8,794,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,551,500.00	1,034,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,066,600.00	827,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	290,900.00	206,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,178,859.00	52,529,566.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,572,951.93	68,227,522.06
210301	Гэрэл, цахилгаан	14,339,058.82	12,769,926.50
210302	Түлш, халаалт	48,618,596.11	51,589,135.56
210303	Цэвэр, бохир ус	4,615,297.00	3,868,460.00
2104	Хангамж, бараа материалын зардал	196,970,110.00	134,218,050.00
210401	Бичиг хэрэг	1,071,190.00	1,521,680.00
210402	Тээвэр, шатахуун	194,517,720.00	130,707,070.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,381,200.00	1,406,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	583,000.00
2105	Нормативт зардал	171,964,540.00	371,223,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	643,500.00	631,750.00
210502	Хоол, хүнс	171,109,440.00	110,592,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	211,600.00	260,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	148,561,000.00	41,742,900.00

**Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210601	Багаж, техник, хэрэгсэл	147,100,100.00	3,914,300.00
210604	Урсгал засвар	1,460,900.00	37,828,600.00
2107	Томилолт, зочны зардал	22,110,848.00	22,882,500.00
210702	Дотоод албан томилолт	22,110,848.00	22,882,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,859,935.00	18,315,256.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	8,287,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	735,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,710,700.00	1,710,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,136,275.00	906,956.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	385,000.00	506,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,167,960.00	3,179,400.00
210807	Газрын төлбөр	3,725,000.00	3,725,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,264,759,202.00	2,609,224,341.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,261,833,802.00	2,598,309,779.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,925,400.00	10,914,562.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	253,039,278.07	143,339,139.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	210,915,800.00	11,228,330.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,116,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	167,799,800.00	11,228,330.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,123,478.07	31,005,444.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,123,478.07	31,005,444.94
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	101,105,364.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	101,105,364.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	57,443,033.00	221,290,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	65,000,000.00	228,340,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,000,000.00	228,340,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	65,000,000.00	228,340,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	65,000,000.00	228,340,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-65,000,000.00	-228,340,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-7,556,967.00	-7,050,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,054,000.00	14,497,033.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,497,033.00	7,447,033.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,193,978,500.00	3,162,973,055.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,193,978,500.00	3,162,973,055.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,186,149,900.00	3,155,144,725.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,579,538,600.00	2,551,779,869.00
210101	Үндсэн цалин	1,502,347,500.00	1,465,090,669.00
210102	Нэмэгдэл	1,034,962,100.00	1,033,280,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,229,000.00	53,408,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,680,100.00	63,393,566.00
210201	Тэтгэврийн даатгал	8,794,700.00	8,794,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,034,700.00	1,034,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	827,700.00	827,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	206,900.00	206,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	52,816,100.00	52,529,566.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,575,200.00	68,227,522.06
210301	Гэрэл, цахилгаан	19,686,400.00	12,769,926.50
210302	Түлш, халаалт	39,475,500.00	51,589,135.56
210303	Цэвэр, бохир ус	9,413,300.00	3,868,460.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,639,600.00	29,547,300.00
210401	Бичиг хэрэг	1,151,500.00	1,087,400.00
210402	Тээвэр, шатахуун	26,470,600.00	26,470,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,381,300.00	1,406,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	636,200.00	583,000.00
2105	Нормативт зардал	371,235,500.00	371,223,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	643,500.00	631,750.00
210502	Хоол, хүнс	110,592,000.00	110,592,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	260,000,000.00	260,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,742,900.00	41,742,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,914,300.00	3,914,300.00
210604	Урсгал засвар	37,828,600.00	37,828,600.00

**Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2107	Томилолт, зочны зардал	1,011,700.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,011,700.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,811,700.00	18,315,256.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,287,000.00	8,287,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,710,700.00	1,710,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,858,200.00	906,956.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,050,500.00	506,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,179,400.00	3,179,400.00
210807	Газрын төлбөр	3,725,900.00	3,725,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10914600.00	10914562.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,914,600.00	10,914,562.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7828600.00	7828330.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,828,600.00	7,828,330.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,828,600.00	7,828,330.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,193,978,500.00	3,193,978,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,193,978,500.00	3,193,978,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,193,978,500.00	3,193,978,500.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	189.00	189.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	176.00	176.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Буян-Ундрах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 28/24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Онцгой байдлын газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, бодлого зохицуулалтыг сайжруулах, үндэсний болон бүс нутаг, олон улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх.
2. Гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж бэхжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, инновацыг нэвтрүүлэх.
3. Байгууллагын удирдлагын манлайлал, хүний нөөцийн хөгжлийг хангаж, чадавхыг бэхжүүлэх.
4. Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх нийтийн үйл хэрэг болгон, иргэд, олон нийтийн гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог хангах.
5. Гамшгаас хамгаалах мэргэжлийн удирдлага зохицуулалтыг сайжруулж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлэх.
6. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, улсын хяналтыг хэрэгжүүлэх замаар галын аюулгүй байдлыг хангах, гал түймэртэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулах.
7. Улсын нөөцийг удирдлага, зохицуулалтаар хангах, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалтыг сайжруулж, гамшгийн дараах үйл ажиллагааг эрчимжүүлэх.
8. Төсөв санхүү, хангалт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх
9. Гамшгаас хамгаалах хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг зохион байгуулж гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол.
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 9,412.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 141.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 105.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Онцгой байдлын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,502.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	1,248.5	1,253.9	5.4
Үндсэн хөрөнгө	7,172.0	9,676.3	2,504.3
Нийт хөрөнгө	8,435.8	10,938.4	2,502.6
Засгийн газрын хувь оролцоо	8,435.8	10,938.4	2,502.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,435.8	10,938.4	2,502.6

Бараа материалын дансны үлдэгдэл 1,253.9 сая төгрөг болж 5.4 сая төгрөгөөр өссөн нь цар тахалтай холбоотой бараа материалын хэрэглээний өсөлтөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,676.3 сая төгрөг болж 2,504.3 сая төгрөгөөр өссөн нь ОБЕГ болон дотоод шилжүүлгээр 2,827.1 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр, 262.5 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,220.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3,220.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 27.0 сая төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 3,193.9 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь улсын төсвийн хөрөнгөөр урсгал зардлыг нэмэгдүүлээгүйтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,193.9 сая төгрөгийг улсын төсвөөс олгохоор төлөвлөжээ

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,193.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, улсын төсөвт 31.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,162.9 сая төгрөг буюу 99 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 3,046.8 сая төгрөгийн орлого буюу цар тахалтай холбоотой хандив /хүмүүнлэгийн тусламж/ 8.5 сая төгрөг, орон нутгаас олгосон 2,422.6 сая төгрөг, дээд шатны байгууллагаас 78.2 сая төгрөг, түргэвчилсэн шинжилгээний орлого 537.4 сая төгрөгийг тус тус төвлөрүүлэн, 101.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгаас хамгаалах дотоод хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын 2.3-т “Мөнгөн хэлбэрээр үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын Төрийн сан дахь нэмэлт дансанд төвлөрүүлэн авч, бүртгэнэ” гэж заасны дагуу тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд иргэн, ААНБ-аас нийт 8.5 сая төгрөг төвлөрснийг зарцуулалгүй орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 68,227.5 сая төгрөгийн 3 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,098.8 сая төгрөгийн зарлагын 88 гүйлгээ, 3,085.3 сая төгрөгийн орлогын 144 гүйлгээ, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 13.9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах 8 тушаалыг бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд 21.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснийг тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Онцгой нөхцөл байдлын үед байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансны бараа үйлчилгээний бусад зардлыг үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 127.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 32.0 сая төгрөгийн алдааг залруулж, 9.4 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 85.5 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд 32,000.0 мянган төгрөгийн авлагыг дутуу илэрхийлсэн байна. Аудитын явцад залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Онцгой байдлын газрын даргын сайшаан шагнах тухай тушаалуудыг үндэслэн албан хаагчдад цалингийн зардлын хэмнэлтээс 6,063.9 мянган төгрөгийг шагнал, урамшуулал хэлбэрээр олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах";, 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.4-т "Төсвийн байгууллага нь батлагдсан тооноос дутуу орон тоогоор ажилласнаас бий болсон төсвийн үлдэгдэл", Сангийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 134 дүгээр тушаалаар батлагдсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1.6-д "Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2. Сахилгын шийтгэл хүлээсэн 3 албан хаагчийн ажлын үр дүнг харгалзан үзэлгүйгээр 3,291.2 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 48.7-д "Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.", Төсвийн тухай хуулийн хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

4.3 Албан шаардлага

1. Орхон аймгийн Засаг даргын 2021 оны 12 сарын 16-ны өдрийн А/692 дугаар захирамжаар ОБГ-ын даргыг 1 сарын үндсэн цалингаар байгууллагын өөрийн төсөвтөө багтаан шагнаж урамшуулах шийдвэр гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.6.2-д "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх";, 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах";, 40.3-д "Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-д "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараахь эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно:", 1.2.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Онцгой байдлын газрын даргын 2021 оны 09 сарын 27-ны өдрийн тушаалаар 1 албан хаагчийн үндсэн цалингийн хэмжээг 1 сарын хугацаатай 10 хувиар бууруулах тушаал гаргасан хэдий ч арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37.1.6-д "харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Бүртгэл санхүүгийн ажилчид удирдлагын хуульд нийцсэн шийдвэрийг цаг тухай бүрт нь хэрэгжүүлж байх.

2. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Гэрэл цахилгааны зардлаас антены төлбөр 330.0 мянган төгрөг шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж байх.

3. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Гамшгийн үед аврах ажиллагаа явуулсан онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдад урамшуулал олгох журамд заасан 12,708.5 мянган төгрөгийн урамшууллыг томилолтын зардлаас олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; Сангийн сайдын 2014 оны Төсвийн эдийн засгийн ангилал батлах тухай 5 дугаар тушаалаар баталсан журмын 6 дугаар хавсралт Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавартай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Гамшгийн үед аврах ажиллагаа явуулсан албан хаагчдад олгох урамшууллыг томилолтын зардлаас гаргахгүй байх.

4. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Орхон аймгийн Баян-Өндөр суманд албан үүргээ гүйцэтгэсэн албан хаагчдад 38,285.5 мянган төгрөгийн урамшууллыг томилолтын зардлаас олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт албан үүргээ гүйцэтгэсэн албан хаагчдад томилолтын зардал олгож байх.

5. Бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Бичиг хэргийн зардлын данснаас 2,155.1 мянган төгрөгийн зардлыг шууд зардалд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14.2-д "Аж ахуйн нэгж,

байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Бүх ажил гүйлгээгээ аккруэл сууриар хөтөлж байх. .

6. Тайлагналтай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 32,000.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...”, 20.2.6-д “... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

6.2. Өгсөн зөвлөмж:

Өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, авлага үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Онцгой байдлын газар	10	127.9	1	32.0	2	9.4	1	1.0	6	85.5
Дүн		10	127.9	1	32.0	2	9.4	1	1.0	6	85.5